

**МАТАД СУМЫН ЕБС-ИЙН 6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Гүйцэтгэх хугацаа- 60 минут
Сурагчийн нэр.....

Нийт оноо 20

А хувилбар

Санамж: Эхийг анхааралтай уншиж ойлгоод асуултад хариулаарай.

Багш шавь хоёр

Урьд нэг лам шавийн хамт амьдардаг байжээ. Шавь нь багшийнхаа хэлсэн сургасан бүхнийг ёсчлон дагадаг маш шударга банди юмсанжээ.

Нэг удаа багш нь айлд залагдаж явахдаа гэр орноо сайн сахиж байна шүү гэж захижээ. Шавь ч гэрээс холдолгүй чин сэтгэлийг барьж багшийн захисныг сахиж суужээ.

Хэд хоноод багш нь иржээ. Гэтэл авдрынх нь ёроол цоорчихсон, дотор нь нандигнан хадгалж байсан эрдэнэ нь алга болсон байв. Багш ламтан хилэгнэн: Гэртээ хүн оруулахгүй сахиж байсан юм бол тэр эрдэнийг чи л авсан байж таарна гээд загнахад шавь нь хэчнээн учирлаад ч үнэмшүүлж чадсангүй гэнэ. Энэ насны минь ганц хөрөнгийг олж өг гэж түүнийг зодоод гэрээсээ хөөв. Шавь нь багшдаа гүтгэгдсэндээ гомдон аргагүйн эрхэнд үхэр тэрэг хөллөн , хэдэн хувцас шоголтой номоо аваад гэртээ буцахаар явжээ. Тэгтэл төд удалгүй тэрэгний өрөөсөн дугуй үлийн нүхэнд цөмрөн орчхов гэнэ.Дугуйг нүхнээс татан гаргатад дотор нь тэргэнд дайрагдаж үхсэн туулай байна гэнэ.

Ажиглавал, багш ламын өнөөх алаг болсон эрдэнэ аманд нь зуулттай байжээ. Эрдэнийн үнэрээр тэр туулай ламын авдрыг цоо мэрсэн юмсанжээ.

- 1. Багшийн энэ насны ганц хөрөнгө нь юу байсан бэ? | 2 оноо|

.....
.....

- 2. Үгийн утгыг тайлбарлаарай. | 2 оноо|

Утгыг тайлбарлах үгс	Утгын тайлбар
----------------------	---------------

Гүтгэгдэх	
үлий	

3. Дээрх эхийн гол санааг хэлцээр илэрхийлэн бичээрэй. | 2 оноо|

.....
.....

4. Багш, шавь хоёрын зан чанарын онцлогт тохирсон хэлц үг тус бүр 1 –ийг олж бичээрэй.

| 2 оноо|

Багш:

Шавь:

5. Өгөгдсөн үйл үгийн үйлийн эзнийг эхээс олоод , ямар үйл үг болохыг зөв харгалзуулаарай. | 2 оноо|

А. хөөв.

1. Эс тусах үйл үг.

Б. цөмрөв.

2. Тусах үйл үг

6. Эхээс ламын зан чанарыг илтгэсэн хэсгийг олж бичээрэй. |5 оноо|

.....
.....
.....

7. Эхийг уншаад кирил бичигт хөрвүүлэн бичээрэй |5 оноо|

ᠠᠩᠭᠤ ᠮᠤᠨ
ᠶ᠋ᠢᠯᠢ ᠵᠤᠨ
ᠵᠡᠭᠦ ᠮᠤᠨ ᠶ᠋ᠢᠯᠢ ᠵᠤᠨ
ᠲᠦᠨᠬᠦᠭᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠢ ᠵᠤᠨ
ᠰᠢᠨᠬᠦᠭᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠢ ᠵᠤᠨ
ᠰᠢᠨᠬᠦᠭᠢᠨ ᠶ᠋ᠢᠯᠢ ᠵᠤᠨ

.....

.....

МАТАД СУМЫН ЕБС-ИЙН 6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Гүйцэтгэх хугацаа- 60 минут

Нийт оноо 20 Сурагчийн нэр.....

Б хувилбар

Санамж: Эхийг анхааралтай уншиж ойлгоод асуултад хариулаарай.
Хариултын олон хувилбараас зөвхөн нэгийг сонгож, дугуйлна.

Зүрх цагаан

Жинчид хол нутагт ачаа бараагаа тушаагаад буцаж явлаа. Шөнө дөлөөр нэгэн хот айлын хажуугаар өнгөрч байв. Гэтэл угсраа тэрэгний цаанаас том халтар нохой босон ирж, учир зүггүй боргоов. Далхаа тэр нохойд яс хаяж өглөө. Нохой олзоо шүүрэн авч харанхуй дунд уусан алга болов.

Тэгтэл зүүн жалганы наанаас зүрх цагаан нохой дайраад ирж гэнэ. Далхаа тэр нохойд яс хаяж өгөв. Зүрх цагаан улам ч догширч уул толгодыг доргиулан боргоож гарлаа. Далхаа тэр нохойд дахин нэг яс хаяж өгөв. Зүрх цагаан бүүр ч гаарч уул, нуруу, хөндий талыг доргитол боргоож амар заяа үзүүлэхгүй байлаа. Далхаа:

-Энэ чинь ёстой монгол нохойн үр сад байна. Удам чинь улам олшрог гэж баярлан хашхирав. Хажууд хүрэн ат унаад зэрэгцэн явсан Цэрэнхүү:

-Түрүүчийнх нь монгол удмын нохой биш үү гэхэд Далхаа:

- Биш ээ, биш. Олз олонгуутаа аваад таг чиг болчихдог тийм өчүүхэн амьтныг би хэзээ ч хүндэлдэггүй юм гэв.

1. Жинчин гэж юу хийдэг хүмүүс вэ? \2 оноо\

.....
.....
.....

2. Нохдын хийсэн үйлийн ялгаа юунд байна вэ? \2 оноо\

-
-

3. Хоёр нохойн аль нь эзэндээ үнэн ч байж чадах вэ? Яагаад? \2 оноо\

.....

 4. Дараах үгсийн утгыг хам сэдвийн хүрээнд тайлбарлаарай. \2 оноо\

Утгыг тайлбарлах үгс	Утгын тайлбар
Боргох	
Жинчин	

5. Өгөгдсөн үйл үгийн үйлийн эзнийг эхээс олоод , ямар үйл үг болохыг зөв харгалзуулаарай.
 \4 оноо\

А. явлаа. 1. Эс тусах үйл үг.

Б. өгөв. 2. Тусах үйл үг

6. Аль нохой нь хоточ нохой вэ? Яагаад? \5 оноо\

.....

7. Монгол бичгийг уншаад кирил бичигт хөрвүүлнэ үү? \5оноо\ Үг бүр 1 оноо



.....
